



САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ
ХОРООНЫ ДАРГЫН
ТУШААЛ

2018 оны 5 сарын 14 өдөр

Дугаар 355

Улаанбаатар хот

┌ Журам батлах тухай ┐

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1.5, Улсын Их Хурлын 2006 оны 45 дугаар тогтоолоор баталсан “Санхүүгийн зохицуулах хорооны дүрэм”-ийн 2.1.6, 3.2 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Санхүүгийн зохицуулах хорооноос хэвлэл мэдээлэл, олон нийттэй харилцах журам”-ыг хавсралтаар баталсугай.

2. Журмыг нийт албан хаагчдад танилцуулж, хэрэгжилтийг хангаж ажиллахыг Хэвлэл, мэдээллийн алба /Д.Энхболдбаатар/-нд даалгаж, тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Ажлын алба /Т.Жамбаажамц/-нд үүрэг болгосугай.


ДАРГА



С.ДАВААСҮРЭН

000773

Санхүүгийн зохицуулах хорооны даргын
2018 оны 5 дугаар сарын 14-ны өдрийн
355 дугаар тушаалын хавсралт



САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНООС ХЭВЛЭЛ МЭДЭЭЛЭЛ ОЛОН НИЙТТЭЙ ХАРИЛЦАХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1 Санхүүгийн зохицуулах хороо (цаашид Хороо гэх)-ны үндсэн зорилт, үйл ажиллагаа, санхүүгийн зах зээлийн тогтвортой байдлыг хангахтай холбогдсон хууль журмын биелэлт, зохицуулалтын арга хэмжээ, зах зээлийн нөхцөл байдлыг Хорооны цахим хуудас, хэвлэл мэдээллийн хэрэгслээр дамжуулан олон нийтэд мэдээлэх, сурталчлах, хэвлэл мэдээллийн байгууллагууд болон олон нийттэй харилцах харилцааг зохицуулахад энэхүү журмын зорилго оршино.

1.2 Энэхүү журам нь Үндсэн хууль, Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хууль, Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай хууль, Төсвийн тухай хууль, Төрийн болон албаны нууцын тухай хууль, Байгууллагын нууцын тухай хууль, Санхүүгийн зохицуулах Хорооны хөдөлмөрийн дотоод журам болон холбогдох бусад хууль тогтоомжид нийцсэн байна.

1.3 Төрийн нууц болон албаны нууцад хамаарахаас бусад Хорооны үйл ажиллагаатай холбоотой мэдээ мэдээллийг нийтэд нээлттэй, шуурхай, бодитой, үнэн зөв хүргэх ажлыг Хэвлэл мэдээллийн алба /цаашид ХМА гэх/ эрхлэн гүйцэтгэнэ.

1.4 Хорооны ХМА-ны үндсэн зорилго нь байгууллагын нээлттэй ил тод байдлыг хангах, үйл ажиллагааны талаар үнэн бодит мэдээлэл түгээх, олон нийтийн санхүүгийн боловсролыг нэмэгдүүлэх, бодлого үйл ажиллагааг сурталчлах замаар олон нийтийн Хороонд итгэх итгэлийг нэмэгдүүлэхэд чиглэнэ.

1.5 Хэвлэл мэдээлэл, олон нийттэй харилцах Хорооны үндсэн арга хэлбэр нь Хэвлэлийн бага хурал, байгууллагын www.frc.mn цахим хуудас байна.

1.6 Энэхүү журмаар зохицуулаагүй бусад нийтлэг харилцааг холбогдох хууль тогтоомжоор зохицуулна.

Хоёр. Хорооны мэдээлэл болон хэрэглэгчийн ангилал

2.1 Хорооноос түгээж байгаа мэдээллийг бодлогын болон бусад мэдээлэл гэж тус тус ангилна.

2.2 Хорооны бодлогын мэдээлэлд Хорооны хуралдааны шийдвэр, Хорооны албан ёсны мэдэгдэл, анхааруулга, зөвлөмж болон цаг үеийн асуудлаар шуурхай хэлбэрээр зохион байгуулан түгээж буй мэдээлэл, хэвлэмэл мэдээлэл, Хорооны дарга, дэд дарга, Ажлын албаны дарга, газрын дарга нарын ярилцлага зэргийг хамруулж ойлгоно.

2.3 Хорооны бусад мэдээлэлд төлөвлөгөөт ажлын хүрээнд зохион байгуулагдаж буй ажил, арга хэмжээний талаарх мэдээ, зах зээлийн тойм, тайлан, статистикийн товхимол болон нийтлэл, орчуулга, зар, тендерийн урилга, ханшийн мэдээ, мэндчилгээ, Хорооны үйл ажиллагааны талаар хэвлэл мэдээллийн хэрэгслүүдэд гарсан ташаа мэдээллийг залруулах залруулга, тайлбар зэрэг багтана.

Гурав. Мэдээлэл түгээх

3.1 Хорооноос мэдээ, мэдээлэл түгээх суваг

3.1.1 Хорооноос олон нийтэд түгээх мэдээ, мэдээлэл нь албан ёсны, үндэслэлтэй, бодитой, анхдагч мэдээлэл байна.

3.1.2 Хороо хэвлэл мэдээллийн байгууллагуудтай нягт хамтран ажиллаж, мэдээлэл түгээх сувагчлал, дэд бүтцээ бүрдүүлэн, олон нийттэй мэдээллээр харилцах урсгалынхаа тасралтгүй, хүртээмжтэй байдлыг хангана.

3.1.3 ХМА-наас Хорооны албан ёсны мэдээллийг цахим хуудсаар болон Хэвлэлийн бага хурал зохион байгуулах хэлбэрээр түгээх бөгөөд Хорооны олон нийтийн сүлжээний хаягаар дэмжин цацна.

3.1.4 Хорооны бодлого, үйл ажиллагаа болон зохион байгуулж буй аливаа арга хэмжээг ХМА цаг тухайд нь шуурхай мэдээлнэ.

3.1.5 Хорооны газар, нэгжүүд хариуцан зохион байгуулж байгаа хурал, сургалт, семинар, зөвлөлгөөн, хэлэлцүүлэг болон бусад арга хэмжээнд ХМА-ны оролцоог хангаж, уг үйл ажиллагааны талаарх мэдээллийг ямар хүрээнд, хэрхэн мэдээлэх, түгээх талаар урьдчилан төлөвлөж, шаардлагатай тохиолдолд төсөв, зардлыг тусган батлуулж ажиллана.

3.2 Хэвлэлийн бага хурал зохион байгуулах

3.2.1 Хорооноос зохион байгуулах Хэвлэлийн бага хурал /цаашид ХБХ гэх/-ын тов, бүрэлдэхүүнийг Хорооны дарга тогтоох ба хурал зарлах, хэвлэлийн мэдээ бэлтгэх болон бусад зохион байгуулалтын ажлыг ХМА хариуцна.

3.2.2 ХБХ-ын үндсэн агуулгыг ХМА-ны дарга танилцуулж болох ба сэтгүүлчдийн асуултад хариулах үүрэг хүлээхгүй.

3.2.3 Хэвлэлийн бага хурлаар Хорооноос гарсан албан ёсны шийдвэр, бодлого, судалгааны дүн, статистик мэдээллийг танилцуулах бөгөөд хувийн байр суурь илэрхийлэхээс зайлсхийнэ.

3.2.4 Хэвлэлийн бага хурлын үеэр сэтгүүлчдэд тараах мэдээлэл, материал, брошюр болон холбогдох баримтыг газар, хэлтсээс урьдчилан бэлтгэсэн байна.

3.2.5 Хэвлэлийн бага хуралд оролцогчид сэтгүүлчидтэй найрсаг байдлыг эрхэмлэн харилцана.

3.3 Цахим хуудсанд мэдээ байршуулах

3.3.1 Хорооны албан ёсны цахим хуудас www.frc.mn нь мэдээллийн үндсэн гарц бөгөөд гадаад, дотоод халдлагаас хамгаалагдсан байна.

3.3.2 Хорооны цахим хуудасны “Мэдээ, мэдээлэл”, “Хуралдааны тойм” цэсийг баяжуулах, хөгжүүлэх болон түгээж байгаа мэдээ, мэдээллийн үнэн зөв, шуурхай байдлыг ХМА хариуцна. Бусад цэсэнд материал оруулах ажлыг Мэдээллийн технологийн хэлтэс эрхэлнэ.

3.3.3 Хорооноос түгээж байгаа мэдээлэл нь хэрэглэгчдэд ойлгомжтой, энгийн, тодорхой байдлаар бэлтгэгдсэн байна.

3.3.4 Цахим хуудсанд байршуулах мэдээллийг заавал ХМА-ны даргад хянуулсан байх ба шаардлагатай тохиолдолд Хорооны дарга болон бусад удирдлагад хянуулна.

3.3.5 Мэдээ хянаж буй удирдах албан тушаалтан нь зөвхөн агуулга хянах ба хэл зүйн болон найруулгын засварыг ХМА-ны дарга хариуцна.

3.3.6 Ажлын албаны нэгжүүд Ажлын албаны даргын 2016 оны 232 тоот тушаалын дагуу Хорооны цахим хуудсанд байршуулах мэдээллийг тухайн өдөр үдийн 12:30 цагаас өмнө ХМА-нд ирүүлнэ. Цаг үеийн болон шаардлагатай мэдээллийг хуваарь харгалзахгүйгээр ХМА-нд ирүүлж, сайтад байршуулна.

Дөрөв. ХМА-ны эрх, үүрэг

4.1 ХМА нь хэвлэл мэдээллийн байгууллагыг Хорооны үйл ажиллагааны мэдээллээр хангах, олон нийтийн мэдээллийн хэрэгсэл ашиглан мэдээлэл түгээх, төлбөртэй сурталчилгааг зуучлах ажлыг зохион байгуулах, олон нийтийн санхүүгийн боловсролыг мэдээллээр дамжуулан нэмэгдүүлэхэд чиглэсэн төсөл хөтөлбөр боловсруулах, хэрэгжүүлэх эрх, үүрэг хүлээнэ.

4.2 Хорооны хуралдаан, Удирдлагын зөвлөлийн хурал, Төрийн дээд байгууллагууд /УИХ, ЭЗБХ, Сангийн яам, СТБЗ/ болон бусад холбогдох хуулийн этгээдийн зохион байгуулж буй хурал, уулзалт, үйл ажиллагаа, хөдөө орон нутаг, гадаад улсад болох арга хэмжээнд ХМА-наас биечлэн оролцож, удирдлагаас өгсөн чиглэлийн дагуу мэдээлэл бэлтгэж түгээнэ. ХМА-наас биеэр оролцуулаагүй үйл ажиллагааг олон нийтэд заавал мэдээлэх үүрэг хүлээхгүй.

4.3 Хэвлэл мэдээллийн хэрэгсэлд гарсан Хорооны бодлого, үйл ажиллагаа, удирдлагатай холбоотой мэдээлэлд ХМА дүн шинжилгээ хийж, шаардлагатай тохиолдолд хариу тайлбар өгөх, ташаа мэдээллийг няцаах бөгөөд хэвлэлийн товч тоймыг бэлтгэн удирдлагуудад танилцуулна.

4.4 Санхүүгийн зохицуулах хорооны бодлогыг олон нийтэд таниулан сурталчлах үйлст идэвхи зүтгэл гаргасан хэвлэл мэдээллийн байгууллага, сэтгүүлчдийг Хорооны болон салбарын шагналаар шагнуулж урамшуулах талаар санал гаргаж, шийдвэрлүүлнэ.

Тав: Хорооноос мэдээ, мэдээлэл хүсэх

5.1 Хэвлэл мэдээллийн байгууллага, сэтгүүлчдээс ирүүлсэн мэдээ, мэдээлэл авах, уулзаж ярилцах хүсэлтийг амаар болон бичгээр холбогдох газрын дарга /эсвэл орлогч/ нарт ХМА-наас хүргүүлнэ. Хариуг ямар байдлаар /шууд, хэвлэлийн хурлаар дамжуулан гэх мэт/ өгөхийг газрын дарга, Хорооны удирдлагуудтай зөвлөлдсөний үндсэн дээр шийдвэрлэх бөгөөд тухайн өдөртөө хэвлэл мэдээллийн байгууллага, сэтгүүлчид эргэн мэдэгдэнэ.

5.2 Хорооны нэр хүндэд ноцтой халдсан онцгой тохиолдолд албан ёсны байр суурь, тайлбар тодруулга, мэдэгдлийг Хорооны дарга, дэд дарга, Ажлын албаны дарга нарын аль нэг нь хийнэ. Албан ёсны байр суурь, тайлбар тодруулга, мэдэгдлийг ямар арга хэлбэрээр, хэрхэн хийхийг Хорооны дарга, дэд дарга, ажлын албатай зөвлөлдсөний үндсэн дээр ХМА зохион байгуулна.

5.3 Гадаадын хэвлэл мэдээллийн байгууллагаас санал ирсэн, эсвэл гадаадын хэвлэл мэдээллийн хэрэгслээр Хорооны үйл ажиллагааны талаар мэдээ, мэдээлэл, танилцуулга, ярилцлага нийтлэх шаардлагатай гэж үзвэл Хорооны даргын өгсөн үүрэг чиглэлийн дагуу Гадаад харилцаа, хамтын ажиллагааны газар зохион байгуулна.

Зургаа. Бусад

6.1 Хэвлэл мэдээллийн хэрэгслээр Хороо, түүний удирдлагын нэр хүндэд ор үндэслэлгүйгээр удаа дараа ноцтой халдсан тохиолдолд асуудлыг холбогдох хууль, тогтоомжийн дагуу шийдвэрлэнэ.

6.2 Хорооны гишүүн болон ажлын албаны ажилтан энэхүү журмыг зөрчсөн тохиолдолд холбогдох хууль, тогтоомж, хөдөлмөрийн дотоод журамд заасны дагуу хариуцлага хүлээлгэнэ.

САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРОО

2018 он